



НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТООЛЛОГО – 2014

Улаанбаатар хот
2015 он

ОРШИЛ

Манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбар юм.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагддаг.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Малын 2014 оны тооллогыг Үндэсний Статистикийн Хорооны даргын 2014 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/103 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан маягт, зааврын дагуу явуулж, үр дүнг дүүргийн түвшинд нэгтгэж гаргалаа.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Мал бүхий өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

Малтай өрх. Мал бүхий өрх, малчин өрхийн нийлбэрээр тодорхойлогдоно.

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр	- 1 бод
1 тэмээ	- 1.5 бод
6 хонь	- 1 бод
8 ямаа	- 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэгжид малд шилжүүлэн малын өсөлт, бууралт, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ	- 5 хонь
1 адуу	- 7 хонь
1 үхэр	- 6 хонь
1 хонь	- 1 хонь
1 ямаа	- 0.9 хонь

Хонин толгойд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлж гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ	- 4 настай, 5 ба түүнээс дээш настай
Адуу	- 3 настай, 4 ба түүнээс дээш настай
Үхэр	- 2 настай, 3 ба түүнээс дээш настай
Бог мал	- тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал.

Тэмээ-өмнөх оны төл,	2 болон 3 настай
Адуу- өмнөх оны төл,	2 настай
Үхэр- өмнөх оны төл	

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал** нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлнэ.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур	-	20-25
Азарга	-	12-15
Бух	-	35-45
Хуц, ухна	-	25-30

Том малын зүй бүс хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Оны эхний малд том малын зүй бүс хорогдлын эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Малын хэрэглээний зарлага. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бүс хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг бод малын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн нийт хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлж малын тоонд харьцуулж тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс	- 0.45
Таримал тэжээл	- 0.35
Даршны ургамал	- 0.25
Гар тэжээл, хужир шүү	- 1.00
Төмс, ногооны хаягдал	- 0.22
Үр тарианы хаягдал	- 0.90
Лай	- 0.40
Сүрэл	- 0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
 1. Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
 2. Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
 3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО: 2014 оны мал тооллогоор хувийн малтай нийт 68 өрх, үүнээс 1 өрх мал аж ахуй эрхэлж байна.

Хүснэгт 1. Малтай, малчин өрх хороогоор

Хороо		2011 он	2012 он	2013 он	2014 он
Нийт мал бүхий өрх	7-р хороо	1	1	1	1
	10-р хороо			1	
	12-р хороо	2	2	1	2
	13-р хороо				
	14-р хороо	5	3	2	2
	15-р хороо	2	1	1	
	16-р хороо	7	2	1	
	17-р хороо	15	16	13	11
	18-р хороо				1
	19-р хороо	66	64	54	51
Дүүргийн дүн		98	89	64	68
Үүнээс малчин өрх	12-р хороо	1	1	1	
	16-р хороо	1	1		
	17-р хороо		2	1	1
	19-р хороо	2	4	2	
Дүүргийн дүн		4	8	4	1

2014 оны байдлаар хувийн малтай 68 өрх байгаа нь өнгөрсөн оноос 4 өрхөөр буюу 6.3 хувиар өсч, харин мал аж ахуй эрхэлж амьжиргааны эх үүсвэрээ болгон амьдарч байгаа малчин өрх 1 байгаа нь өнгөрсөн оноос 3 буюу 33.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Малтай болон малчин өрхийн ам бүл, малчдын тоо


Төрөл	2011 он	2012 он	2013 он	2014 он
Нийт мал бүхий өрх	98	89	74	68
Түүний ам бүл	318	269	221	187
Үүнээс: Малчин өрх	4	4	4	1
Ам бүл	14	14	19	1
Малчдын тоо	12	12	14	1
16-34 насны	5	5	6	1
35-аас тэтгэвэрт гарах насны	3	3	4	
Тэтгэврийн насны	4	4	4	
Нийт малчдаас эмэгтэй	5	5	8	1
Насны бүтэц	100.0	100.0	100.0	100.0
16-34 насны	41.7	41.7	42.8	100.0
35-аас тэтгэвэрт гарах насны	25.0	25.0	28.6	
Тэтгэврийн насны	33.3	33.3	28.6	

МАЛЫН ТОО, БҮТЭЦ: 2014 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 1840 толгойд хүрч, өнгөрсөн оныхоос 476 толгой малаар буюу 34.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Малын тоо, төрлөөр

Төрөл	2011 он	2012 он	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	
					тоо	хувь
Адуу	19	22	15	35	20	133.3
Үхэр	716	692	555	658	103	18.5
Хонь	141	211	207	421	214	103.4
Ямаа	431	603	587	726	139	23.7
Нийт мал	1307	1528	1364	1840	476	34.9

Малын тоо, оноор



2014 оны мал тооллогоор дүүргийн мал сүрэг төрөл тус бүр дээр өссөн бөгөөд адуун сүрэг 20 толгойгоор буюу 133.3 хувиар, үхэр сүрэг 103 толгой буюу 18.5 хувиар, хонин сүрэг 214 толгой буюу 103.4 хувиар, ямаан сүрэг 139 толгой буюу 23.7 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 4. Малын тоо, хороогоор

Хороо	2013 он	2014 он	Үүнээс				Өсөлт, бууралт	
			Адуу	Үхэр	Хонь	Ямаа	тоо	хувь
7-р хороо	8	7	1	6			-1	12.5
10-р хороо	10						-10	100.0
12-р хороо	181	17		17			-164	90.6
14-р хороо	13	17		17			4	30.8
15-р хороо	7						-7	100.0
16-р хороо	6						-6	100.0
17-р хороо	346	610	1	71	234	304	264	76.3
18-р хороо		4	1	3			4	
19-р хороо	793	1185	32	544	187	422	392	49.4
Дүн	1364	1840	35	658	421	726	476	34.9

Дүүргийн хэмжээнд малын тоогоор 19 дүгээр хороо хамгийн их малтай буюу нийт малын 64.4 хувь, хамгийн их хонин сүрэгтэй хороогоор 17 дугаар хороо 234 толгойгоор, хамгийн бага малтай хороогоор 18 дугаар хороо байна.

Хүснэгт 5. Малын орлого, зарлага, төрлөөр

Төрөл	Орлого			Зарлага					
	Худалдаж авсан	Шилжиж ирсэн	Бэлэн тоологдсон	Худалдсан	Шилжүүлсэн	Алдсан	Зах зээлд борлуулсан	Хүнсэнд хэрэглэсэн	Зүй бус хорогдол
Адуу	2	16	6		2	2			
Үхэр	22	42	241	11	58	6	31	88	8
Хонь		144	127		10	1	9	35	2
Ямаа	12	189	225		199	6	10	65	7
Дүн	36	391	599	11	269	15	50	188	17

Дээрх хүснэгтээс харахад орлого талыг худалдаж авсан болон шилжиж ирсэн 427 толгой мал, бэлэн тоологдсон төл 599 толгойгоор бүрдүүлж харин худалдсан 11 толгой, шилжүүлсэн 269, алдсан 15, зах зээлд борлуулсан 50, хүнсэнд 188, зүй бус хороглоор 17 толгой мал хорогдож зарлага талыг тус тус бүрдүүлсэн байна.

Хүснэгт 6. Нийт малд эзлэх хувийн жин, төрлөөр

Төрөл	2011 он	2012 он	2013 он	2014 он
Нийт мал	100.0	100.0	100.0	100.0
Адуу	1.4	1.4	1.1	1.9
Үхэр	54.8	45.3	40.7	35.8
Хонь	10.8	13.8	15.2	22.9
Ямаа	33.0	39.5	43.0	39.4


Үүнээс харахад малын сүргийн бүтэц сүүлийн 4 жил харьцангуй хэвийн байна. Нийт малын 62.3 хувийг бог мал эзэлж байна.

Бог малын 36.7 хувийг хонин сүрэг, 63.3 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

ХЭЭЛТЭГЧ МАЛ: 2014 оны эцэст 912 толгой хээлтэгч мал тоологдож өнгөрсөн оноос 230 толгойгоор буюу 33.7 хувиар өссөний дотор гүү 8 толгой, үнээ 63 толгой, эм хонь 62 толгой, эм ямаа 97 толгойгоор тус тус өссөн байна.

Хүснэгт 7. Хээлтэгч мал, төрлөөр

Төрөл	2011 он	2012 он	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	
					тоо	хувь
Гүү			2	10	8	400.0
Үнээ	370	296	305	368	63	20.6
Эм хонь	57	73	98	160	62	63.3
Эм ямаа	179	218	277	374	97	35.0
Бүгд	606	587	682	912	230	33.7



Хээлтэгч малын тоо

Хээлтэгч мал нийт мал сүргийн 49.5

хувийг эзэлж байгаа бөгөөд

- адуун сүргийн 28.6 хувь
- үхэр сүргийн 55.9 хувь
- хонин сүргийн 88.8 хувь
- ямаан сүргийн 51.5 хувийг

тус тус эзэлж байна.

БЭЛЭН ТООЛОГДСОН ТӨЛ: Энэ оны мал тооллогоор бэлэн тоологдсон төлын тоо 711 толгой болж өнгөрсөн оноос 124 толгойгоор буюу 21.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 8. Бэлэн тоологдсон төл, төрлөөр

Төрөл	2011 он	2012 он	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	
					тоо	хувь
Унага	2	10		6	6	
Тугал	432	432	296	301	5	1.7
Хурга	60	70	73	127	54	74.0
Ишиг	214	214	218	277	59	27.1
Бүгд	708	726	587	711	124	21.1

Өнгөрсөн оны тооллогоор 682 толгой хээлтэгч тоологдсон бөгөөд

- хээлтэй малын орлогоор 399 толгой мал нэмэгдэж
- хээлтэй 169 толгой мал зарлагдаж
- сувайрсан 203 толгой мал хасагдаж 709 хээлтэгч төллөсөн байна.

Хүснэгт 9. Төл бойжилт, төлийн орлого, зарлага, төрлөөр

Төрөл	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдсан	Шилжүүлсэн
Унага	6	6		6		
Тугал	305	305	4	301	2	58
Хурга	127	127		127		
Ишиг	271	277		277		52
Бүгд	709	715	4	711	2	110

2014 онд 715 төл хүлээн авч 4 төл хорогдож төл бойжилт 99.4 хувьтай байна. Өнгөрсөн онд 6 ихэр ишиг хүлээн авсан байна.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ: 2014 оны тооллогоор 17 том мал хорогдсон бөгөөд энэ нь өмнөх оноос 8 толгой буюу 88.9 хувиар өссөн байна. Нийт хорогдсон малын 47.0 хувийг үхэр, 11.8 хувийг хонь, 41.2 хувийг ямаа эзэлж байна.

Хүснэгт 10. Том малын зүй бус хорогдол, төрлөөр

Төрөл	2011 он	2012 он	2013 он	2014 он	Өсөлт, бууралт	
					тоо	хувь
Адуу						
Үхэр	10	10	9	8	-1	11.1
Хонь				2	2	
Ямаа				7	7	
Бүгд	10	10	9	17	8	88.8

ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРГОО: 2014 онд 11 хээлтүүлэгч мал тоологдож, өмнөх оноос 8 толгойгоор буюу 42.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 11. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохиргоо

Төрөл	Хээлтүүлэгчийн тоо	Үржлийн норм	2011 он	2012 он	2013 он	2014 он
Гүү	4	15			2	3
Үнээ	6	45	62	42	101	52
Эм хонь	5	30	11	24	14	41
Эм ямаа	11	30	20	22	31	34

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохиргоо бод мал буюу адуу, үхэр сүргийн хувьд алдагдаж байна. Бог мал дээр харьцангуй зохистой харьцаатай болж байна.

Үржлийн нормоор бод малын хээлтүүлэгчид буюу 1 бухад 35-45 хээлтэгч ногдох ёстой атал өнгөрсөн оны тоологоор дүүрэгт дунджаар 52 үнээнд 1 бух ногдож байна.

ТЭЖЭЭВЭР АМЬТАД: Мал тэжээвэр амьтдын 2014 оны тооллогоор 43 өрхийн 25 гахай, 2 туулай, 2 илжиг, 620 тахиа, 59 галуу, 43 тагтаа, 28 цацагтхяруул, 10 нугас тоологдсон байна.

Хүснэгт 12. Тэжээвэр амьтдын тоо

Төрөл	2011 он	2012 он	2013 он	2014 он
Гахай	0	7	8	25
Шувуу	506	475	503	760
Үүнээс: тахиа	378	266	436	620

ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР МУУР, НОХОЙ: Дүүргийн нийт 19 хороонд тэжээвэр 9112 нохой, 140 муур бүртгэгдсэн байна. Бүртгэлийн дүнг өмнөх оныхоос нохой 52 буюу 0.5 хувиар буурч, муур 36 буюу 34.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 13. Тэжээвэр нохой, муурны тоо, хороогоор

Хороо	Нохой			Муур		
	2013 он	2014 он	Өсөлт, бууралт /тоо/	2013 он	2014 он	Өсөлт, бууралт
1-р хороо	7	22	15		1	1
2-р хороо	19	7	-12	1		-1
3-р хороо	22	22	0	5	5	0
4-р хороо	14	24	10	4	3	-1
5-р хороо	17	11	-6	1	1	0
6-р хороо	14	17	3		1	1
7-р хороо	1097	1161	64	12	12	0
8-р хороо	373	331	-42		2	2
9-р хороо	281	238	-43		2	2
10-р хороо	401	440	39		12	12
11-р хороо	521	466	-55	4	10	6
12-р хороо	833	951	118		15	15
13-р хороо	795	749	-46	10	9	-1
14-р хороо	616	603	-13		2	2
15-р хороо	493	581	88	5		-5
16-р хороо	880	892	12	25	7	-18
17-р хороо	881	728	-153	10	36	26
18-р хороо	815	764	-51	11	3	-8
19-р хороо	1085	1105	20	16	19	3
Нийт	9164	9112	-52	104	140	36

Тэжээвэр нохойны тоо 1,4,6,7,10,12,15,16,19-р хороодод 5.8 хувиас 2 дахин өссөн бол 2,5,8,9,11,13,14,17,18-р хороодод буурсан байна. Нийт бүртгэгдсэн тэжээвэр нохойны хамгийн их буюу 12.0 хувь нь 7 дугаар хороонд байна.

Тэжээвэр муурны хамгийн их буюу 72.2 хувь нь 17 дугаар хороонд байна.

Дүгнэлт

Чингэлтэй дүүрэг 2014 оны мал тооллогын дүнгээр 1840 толгойд хүрч өнгөрсөн оноос 34.9 хувиар буюу 476 толгой малаар өслөө. Энэ жилийн малын өсөлтөнд бэлэн тоологдсон төл, худалдаж авсан болон шилжиж ирсэн малын өсөлт, хээлтэгч малын өсөлт зэрэг нөлөөлсөн байна.

Бог малын бүтцэд 201 оны байдлаар 36.7 хувийг хонин сүрэг, 63.3 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Нийт малыг хонин толгойд шилжүүлснээр 5267 толгойд хүрч өссөн байгаа ч дүүргийн бэлчээрийн талбай жил ирэх тусам буурч байгаа нь малын бэлчээрийн газар хомс болж, бэлчээрийн даац хэтэрч байгааг илтгэж байна.

Манай дүүргийн хувьд малын тоогоор Нийслэлийн 9 дүүргээс 8-д орж байна.

Түүнчлэн дүүргийн хэмжээнд 789 тэжээвэр амьтад тоологдсон. /Гахай 25, тахиа 620, галуу 59, тагтаа 43, цацагтхяруул 28, нугас 10, туулай 2, илжиг 2/

Нийт мал сүргийн дотор адуу 1.9 хувь, үхэр 35.8 хувь, хонь 22.9 хувь, ямаа 39.4 хувийг эзэлж байна. Нийт мал сүргээс хээлтэгч мал 49.3 хувийг, төл 38.6 хувийг эзэлж байна. 2014 онд 715 төл хүлээж авснаас 711 төл бойжиж, төл бойжилтын хувь 99.4 хувьтай байна.